



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ САЛБАРЗӨВЛӨЛИЙН 2017ОНЫҮЙЛАЖИЛЛАГААНЫХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2017.06.29

Сүхбаатар сум

Төрийн үйлчилгээний ил тод, шуурхай байдлыг ханган, төрийн албан хаагчдын ёс зүйн хариуцлагыг өндөржүүлж, цомхон, чадварлаг, үр дүнд чиглэсэн төрийн албыг бүрдүүлэх, төрийн албаны шинэтгэлийг орон нутагт хэрэгжүүлэх, төрийн удирдах албан тушаалтны манлайллыг дээшлүүлэхэд гол үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн

2017 оны хагас жилийн хуралдааны тойм

№	Салбар зөвлөлийн хуралдаан	Хуралдаан болсон огноо	Хэлэлцсэн асуудлын тухай	Шийдвэрлэлт
1	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаан №01	2017.01.27	Салбар зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл	6 бүлэг 15 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг эцэслэн баталсан
2	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаан №02	2017.03.31	1.Төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэв олгох тухай 2.Төрийн албаны салбар зөвлөлд ирүүлсэн хүсэлтийн тухай -Э.Нандин-Эрдэнийг Сүхбаатар сумын ЗДТГ-ын даргын албан тушаалд ажиллуулах дүгнэлт гаргах тухай 3.Төрийн албаны салбар зөвлөлд ирүүлсэн өргөдөл гомдлын тухай -Шаамар сумын Дулаанхаан тосгоны иргэн Н.Энхтуяа 4."Төрийн албаны тэргүүний ажилтан" цол тэмдгээр шагнуулах тухай -УЦУОША-ны дарга М.Рэгзэдмаа -Гадаадын иргэн, харьяатын газар Хойд бүс дэх газрын шалган нэвтрүүлэх албаны мэргэжилтэнЧ.Лхагвасүрэн -Хушаат сумын ИТХ-ын	1. Төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэв олгох тухай асуудлыг хэлэлцэж 114 төрийн захиргааны албан хаагчдад зэрэг дэв олгохоор аймгийн Засаг даргад уламжлахаар тогтов. 2. Э.Надин-Эрдэнийн үр дүнгийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтыг ирүүлэх албан тоотыг хүргүүлэхээр шийдвэрлэсэн. 3. Шаамар сумын Дулаанхаан тосгоны иргэн Н.Энхтуяагийн өргөдлийн дагуу Шаамар сумын ЗДТГ-ын даргад ТАЗСЗ-ийн албан бичгээр хариуг хүргүүлэхээр шийдвэрлэсэн. 4. "Төрийн албаны тэргүүний ажилтан" цол тэмдгээр шагнуулахаар тодорхойлсон УЦУОША-ны дарга М.Рэгзэдмаа -Гадаадын иргэн, харьяатын газар Хойд бүс дэх газрын шалган нэвтрүүлэх албаны



Төрийн албаны зөвлөлийн
Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл



			<p>нарийн бичгийн дарга П.Ариунаа -Хушаат сумын ЗДТГ-ын ТЗХЭЗ асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Өнөржаргал -Орхон сумын өндөр настан Б.Бямбаа 5.Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын ЗДТГ-ын хүний нөөцийн холбогдолтой шийдвэрийн үндэслэл, боловсруулалтанд хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулах тухай</p>	<p>мэргэжилтэн Ч.Лхагвасүрэн нарын шагналын баримт бичгийг бүрдүүлэн Төрийн албаны зөвлөлд уламжлахаар тогтсон. -Хушаат сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга П.Ариунаа -Хушаат сумын ЗДТГ-ын ТЗХЭЗ асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Өнөржаргал -Орхон сумын өндөр настан Б.Бямбаа нарын баримт бичгийн бүрдүүлэлтийн шаардлага хангаагүйгээс материалыг буцаав. 5. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын ЗДТГ-ын хүний нөөцийн холбогдолтой шийдвэрийн үндэслэл, боловсруулалтанд хяналт шалгалт хийх ажлын хэсэг томилогдож ажиллахаар шийдвэр гарсан.</p>
3	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаан №03	2017.06.19	<p>1.Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд ирүүлсэн өргөдөл, гомдлын тухай - Баянгол сумын ЗДТГ-ын газрын даамал Г.Саранцэцэгийн ажлаас үндэслэлгүй халагдсан тухай - Санхүүгийн хяналт аудитын албаны дарга Б.Дарихжав гомдол гаргах тухай - Цагааннуур сумын 2-р багийн иргэн Н.Отгонсансарын ажлаас үндэслэлгүй халагдсан тухай - Сүхбаатар сумын 3-р цэцэрлэгийн эрхлэгч П.Амарсанаад сахилгын шийтгэл үндэслэлгүй ноогдуулсан тухай 2."Төрийн албаны тэргүүний ажилтан" цол тэмдгээр шагнуулах тухай - Сүхбаатар боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч Л.Бямбаа 3.Төрийн албаны мэргэшлийн шалгалтын нөөцөөс нөхөх арга хэмжээний тухай</p>	<p>1. Баянгол сумын ЗДТГ-ын газрын даамал Г.Саранцэцэгийн ажлаас үндэслэлгүй халагдсан тухай өргөдлийг ажлын хэсэг томилогдон газар дээр нь шалгаж эгүүлэн ажилд томилох тухай тогтоолыг хүргүүлэв. - Санхүүгийн хяналт аудитын албаны дарга Б.Дарихжавын өргөдлийг хэлэлцэж ТАЗСЗ-ийн 2017 оны 50 дугаар албан бичгээр хариуг хүргүүлэв. - Цагааннуур сумын 2-р багийн иргэн Н.Отгонсансарын өргөдлийн дагуу хэлэлцэж Цагааннуур сумын сургуулийн захиралд ТАЗСЗ-ийн 2017 оны 53 дугаар албан бичгээр хариуг хүргүүлэв. - Сүхбаатар сумын 3-р цэцэрлэгийн эрхлэгч П.Амарсанаагийн өргөдлийг хэлэлцэж ТАЗСЗ-ийн 2017 оны 51 дүгээр албан бичгээр хариуг хүргүүлэв. - "Төрийн албаны тэргүүний ажилтан" цол тэмдгээр шагнуулахаар тодорхойлсон Сүхбаатар боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны</p>



Төрийн албаны зөвлөлийн
Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл



		<p>-Эрүүл мэнд нийгмийн даатгалын хэлтсийн Шаамар сумын нийгмийн даатгалын байцаагчийн албан тушаалд Алтангэрэл овогтой Энх-Амгалан материалаа ирүүлсэн тухай</p> <p>4.Төрийн албаны салбар зөвлөлийн №2 хуралдаанаар хэлэлцэж явуулсан албан тоотын хариуны тухай</p> <p>- Шаамар сумын ЗДТГ-ын Санхүүгийн албаны төрийн сангийн мэргэжилтний албан тушаалд Н.Энхтуяаг томилсон шийдвэрийн тухай</p> <p>-Сүхбаатар сумын ЗДТГ-ын даргын анкет, ажлын байрны тодорхойлолт</p>	<p>Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч Л.Бямбаагийн шагналын баримт бичгийг бүрдүүлэн Төрийн албаны зөвлөлд уламжлахаар тогтсон.</p> <p>3.Төрийн захиргааны албан тушаалын сул орон тоог нөөцөөс нөхсөн арга хэмжээний дагуу Эрүүл мэнд нийгмийн даатгалын хэлтсийн Шаамар сумын нийгмийн даатгалын байцаагчийн албан тушаалд 1 хүн бүртгүүлснийг хэлэлцэж нэр дэвшүүлэхээр тогтов.</p> <p>- Шаамар сумын ЗДТГ-ын Санхүүгийн албаны төрийн сангийн мэргэжилтний албан тушаалд Н.Энхтуяаг томилсон тухай хариу шийдвэртэй танилцсан.</p> <p>- Сүхбаатар сумын ЗДТГ-ын даргын албан тушаалд Э.Нандин-Эрдэнийг нэр дэвшүүлэхээр шийдвэрлэсэн.</p>
--	--	---	---

Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэрийн талаарх мэдээ, мэдээллийг аймгийн албан ёсны цахим хуудсанд байрлах “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл” гэсэн талбарт байршуулан мэдээлэх ажлыг тогтмолжууллаа.

Аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд Төрийн албатай холбоотой асуудлаар 9 төрийн албан хаагчийн өргөдөл, гомдол ирснийг бүртгэн холбогдох хууль, журмын дагуу тухай бүр нь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүдээр ахлуулсан ажлын хэсэг томилон дүгнэлт гаргуулж, салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн хуулийн хугацаанд нь шийдвэрлэж ажиллалаа.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хандсан өргөдөл гомдлын шийдвэрлэлт:

№	Өргөдөл гаргагчийн нэр	Өргөдлийн утга	Шалгасан ажлын хэсэг	Шийдвэрлэсэн байдал	Тайлбар
1	Т.Гантулга	Хариуцлага тооцох тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар	Зүүнбүрэн сумын ЗДТГ-ын дарга Д.Гантулга, Алтанбулаг сумын ЗДТГ-ын дарга Ү.Янжиндулам нарт ТАЗСЗ-ийн 2017	



Төрийн албаны зөвлөлийн
Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл



				оны 11 дүгээр албан бичгээр хариу хүргүүлсэн.	
2	С.Чойсүрэн	Ажлаас халагдсан тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Алтанбулаг сумын иргэн С.Чойсүрэнд ТАЗСЗ-ийн 2017 оны 24 дүгээр албан бичгээр хариу хүргүүлсэн.	Хуулийн байгууллагад хандахыг зөвлөсөн.
3	Т.Гантулга	Нэр дэвшүүлэх тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Сүхбаатар сумын Засаг дарга Т.Гантулгад ТАЗСЗ-ийн 2017 оны 32 дугаар албан бичгээр хариу хүргүүлэв.	Баримт бичиг баталгаажуулж ирүүлэхийг мэдэгдсэн.
4	Н.Энхтуяа	Ажилд авахгүй байгаа тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Шаамар сумын иргэн Н.Энхтуяад ТАЗСЗ-ийн 2017 оны 33 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн.	Н.Энхтуяа нь Шаамар сумын ЗДТГ-ын Төрийн сангийн гүйлгээ хариуцсан мэргэжилтнээр томилогдсон.
5	Ж.Түвшинжаргал	Нэр дэвшүүлэх тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Мандал сум дахь Шүүхийн Тамгын газрын дарга Ж.Түвшинжаргалд ТАЗСЗ-ийн 2017 оны 43 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн.	П.Нямсүрэнг Мандал сумын сум дундын Шүүхийн тамгын газрын шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалд нэр дэвшүүлж байна.
6	Г.Саранцэцэг	Ажлаас үндэслэлгүй халагдсан тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Баянгол сумын иргэн Г.Саранцэцэгт ТАЗСЗ-ийн 2017 оны 48 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн.	Одоогоор эгүүлэн томилоогүй байгаа.
7	Б.Дарихжав	Засаг даргын захирамжийг хүчингүй болгох тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Санхүүгийн хяналт аудитын албаны дарга Б.Дарихжавд 2017 оны 50 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн.	-
8	П.Амарсанаад	Засаг даргын	ТАЗСЗ-ийн хуралдаанаар	СБ сумын 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч	-



Төрийн албаны зөвлөлийн
Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл



		захирамжийг хүчингүй болгох тухай	хэлэлцсэн	П.Амарсанаад 2017 оны 51 дүгээр албан бичгээр хариуг хүргүүлсэн.	
9	Г.Сугар	Шүүхийн шийдвэрийг и биелүүлж ажиллахгүй байгаа тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Цагааннуур сумын сургуулийн захирал Г.Сугарт 2017 оны 53 дугаар албан бичгээр хариуг хүргүүлсэн.	Шүүхийн шийдвэрээр эргэн ажилдаа орох болсон.

Салбар зөвлөлийн үйл ажиллагааны нээлттэй байдал, үйл ажиллагааг сурталчилсан байдал, үр дүн:

Төрийн албаны хууль тогтоомжийн болон хэрэгжилтийнталаарх төрийн байгууллагаас хийж хэрэгжүүлж буй ажил арга хэмжээний талаарх мэдээлэл авах боломжоор хангах үүднээс аймгийн **“Selenge.gov.mn”** цахим хуудсандцаг үеийн шуурхай мэдээллүүдийг байршуулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын сар тутмын **“Өргөн Сэлэнгэ”** мэдээллийн сонин гарган үйлчилж байна. Сонины дугаар бүрт төрийн үйлчилгээний үйл ажиллагааны талаар иргэдээс мэдээлэл авах утас, хаяг, хариу мэдээллийг тогтмол нийтэлдэг болсон. Энэхүү мэдээллийн хуудсыг 17 сум, 6 тосгонд тухай бүр хуваарилан хүргүүлж иргэдэд түргэн шуурхай хүргэх ажлыг зохион байгуулж хэвшлээ.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн самбарт Монгол Улсын Төрийн албаны зөвлөл, Салбар зөвлөлийн шийдвэр, цаг үеийн мэдээ, мэдээлэл, төрийн албан хаагчдын тоо бүртгэлийн талаар болон хийж хэрэгжүүлж буй ажил арга хэмжээг самбарт байршуулж сурталчлах ажлыг тогмолжуулаад байна. Мөн төвийн “Зууны мэдээ” сонин, Монголын үндэсний болон TV-9 телевизорон нутгийн, “Сэлэнгийн мэдээ”, “Шинэ гэгээ” сонин “Миний Монгол” кабелийн телевиз, аймгийн Засаг даргын Тамгын газраас эрхлэн гаргадаг “Өргөн Сэлэнгэ” сар тутмын мэдээллийн сонин зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс явуулж буй цаг үеийн ажил арга хэмжээний талаар ярилцлага өгөх, нийтлэх зэргээр сурталчлах ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.



Төрийн албаны зөвлөлөөс өгсөн хугацаатай үүрэгдаалгаврын биелэлт:

2017 онд Төрийн албаны зөвлөлөөс ирсэн тогтоол, зөвлөмж, заавар журмын мөрөөр хийсэн ажлын талаарх судалгааг дараах байдлаар гаргалаа.

**Төрийн албаны зөвлөлөөс 2017 онд ирсэн
албан бичгийн шийдвэрлэлт:**

№	Огноо	Дугаар	Хаанаас ирсэн	Бичгийн утга	Хэрэгжилт
Хугацаатай тайлан мэдээний тухай					
1	2017.02.01	142	Төрийн албаны зөвлөл	Баримт бичиг ирүүлэх тухай	Баянгол сумын ЗДТГ-ын Нийгмийн ажилтны албан тушаалд нэр дэвшсэн Гөлөгөөжавын Цэрэнжамбын мэргэшлийн шалгалтын баримт бичгийг 2017 оны 21 дүгээр албан бичгээр хүргүүлэв
2	2017.02.21	219	Төрийн албаны зөвлөл	Баримт бичиг ирүүлэх тухай	Зүүнбүрэн сумын Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын Хөдөлмөр, нийгмийн халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд нэр дэвшсэн Отгонбаатарын Бадамхандын мэргэшлийн шалгалтын баримт бичгийг 2017 оны 23 дугаар албан бичгээр хүргүүлэв.
3	2017.06.15	781	Төрийн албаны зөвлөл	Сургалтад нэр дэвшүүлэх тухай	2017 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 56 дугаар албан тоотой хариуг хүргүүлсэн.
Тогтоол, заавар, зөвлөмжийн талаар:					
1	2017.03.22	347	Төрийн албаны зөвлөл	Зөвлөмж хүргүүлэх тухай	Зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж төрийн албаны зөвлөлд хагас жилийн байдлаар тайлагнав.
2	2017.04.19	482	Төрийн албаны зөвлөл	Зөвлөмж хүргүүлэх тухай	Зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж төрийн албаны зөвлөлд хагас жилийн байдлаар тайлагнав.

Тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөлөөс судалгаа, тайлбар ирүүлэх тухай хугацаатай 3, салбар зөвлөлийн чиг үүрэгтэй холбоотой тогтоол, заавар, зөвлөмж 2 ирснийг бүртгэн холбогдох арга хэмжээг авч хугацаанд нь тайлагнах ажлыг зохион байгууллаа.



ДҮГНЭЛТ:

Төрийн албатай холбоотой хууль тогтоомж, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журмыгүйл ажиллагааны удирдлага болгон тайлант хугацааныхаа зорилго, зорилтын хэрэгжилтийг хангах, орон нутгийн хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх, стандартын удирдлагаар ханган мэргэшил арга зүй, бодлогын дэмжлэг үзүүлэх, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог нэвтрүүлэхэд гол үйл ажиллагаагаа чиглүүлэнтөлөвлөсөн ажил арга хэмжээг амжилттай хэрэгжүүлэн ажиллалаа. Хариуцлага үр дүнгийн жил болгон зарласантай холбогдуулж бүх шатны ажиллаж буй төрийн албан хаагчид, ажлын хэсгүүдийг идэвхижүүлж ажлын хэсгийг шинээр нэмж байгуулсан. Тухайлбал:

1. Авлигын эсрэг үйл ажиллагааг эрхлэх орон тооны бус зөвлөл
2. Орон тооны бус спортын зөвлөл
3. Ёс зүйн хороог шинэчлэн байгуулах
4. Бүтээмжийн ажлын хэсэг
5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлын хэсэг
6. Хөдөлмөрийн маргаан таслах комисс
7. Өмч хамгаалах байнгын зөвлөл

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛ